

"Ландшафтын дизайн" холимог цахим хичээлд өгөх санал

С.Бямбагэрэл миний бие МУИС-ийн ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн Ойн аж ахуйн хөтөлбөрт Хот суурин цэцэрлэгжүүлэлт (FORS403) хичээлийг 2021-2022 оны намрын улиралаас эхлэн зааж байна.

ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Таримал судлал, Ой, Ландшафтын архитектурын тэнхимийн багш доктор С.Одонгэрэл болон доктор Д.Банзрагч нарын боловсруулсан Ландшафтын дизайн (ARCH707) хичээлийн тодорхойлолтонд өгөх саналыг дараах байдлаар хүргүүлж байна.

1. Энэ хичээлийн зорилго ландшафтын дизайны онол болон хотын орон зайн дизайны хувьслыг судалж, түүх, урлаг, соёлын талаарх ойлголт, тэдгээрийн судалгаанд үндэслэн төлөвлөлтийн дизайнд анализ хийх арга, аргачлалын талаар мэдлэг олгоход чиглэгдэнэ. Тус хичээлийн агуулга нь ландшафтын дизайны үйл явц, нөлөө, тэдгээрийн тусгаж буй урлагийн чиглэлийг ойлгох, дүрслэх, аналитик ур чадвар олгохоор тодорхойлохдоо нийт 18 цагийн лекц, 18 цагийн дадлагын хичээлд багтаан хийхээр төлөвлөсөн байна. Сургах болон сурах үйл явц нь шавь төвт сургалтын арга барилд тулгуурлах ба лекц, харилцан яриа, лабораторийн ажил, бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, мэдээлэл цуглуулах, түүнд анализ хийх, илтгэл тавих гэх мэт олон хэлбэрээр явуулахаар төлөвлөсөн нь ахисан түвшний шаардлагад бүрэн нийцсэн гэж үзэж байна.
2. Тус хичээлийн ерөнхий агуулга, заах хэлбэр болон үнэлгээ мөн хичээлийг үнэлэх арга нь МУИС-ийн сургалтын журамтай бүрэн нийцэж байгаа бөгөөд МУИС-ийн цахим хичээлийн нэг болсон нь зөвхөн тус хөтөлбөрийн оюутнууд биш бас энэ чиглэлээр сонирхон сурах иргэд болон судалгаа, шинжилгээний ажлаа хийдэг төгссөн мэргэжилтэнүүд өөрсдийн ур чадвараа нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд бие даан суралцах боломжийг бүрэн хангасан гэж үзэж байна (<https://online.num.edu.mn/courses>).
3. Энэ хичээлийн онолын мэдлэг олгох лекцийг бататгахад үндсэн сурах бичиг болох сурах бичиг нь Antonio Missiroli, Gerald Stang, Jan Joel Andersson, Cristina Barrios, Florence Gaub, Eva Gross, Patryk Pawlak, Eva Pejsova, Nicu Popescu and Thierry Tardy, (2014) The human environment, European Union Institute for Security Studies (EUISS) гэсэн бүтээл нь цахим файл хэлбэрээр байгаа боловч сурч буй оюутнуудын хэлний ур чадвар уг бүтээлийг уншиж ашиглахад учир дутагдалтай байж болох юм. Харин хичээл заах багш, доктор Одонгэрэлийн Ландшафтын архитектурын урлагийн түүх номыг МУИС-ийн ном сан болон бусад номын худалдааны каталогоос хайгаад олсонгүй. Иймд 2021 онд хэвлэгдсэн уг бүтээлийг сургуулийн болон бусад номын сангийн каталогт оруулж суралцагчдад хангалттай болгох тал дээр анхаарна уу.
4. Мөн бие даалт эсвэл дадлагын хичээл дээр зарим нэг ландшафтын олон нийтэд нээлттэй программ хангамж дээр ажиллуулж сургах нь зүйтэй гэж бодож байна. Тухайлбал худалдан авах лиценз шаардлагагүй Gardenplanner, Edrawsoft болон i-Tree Landscape зэрэг программуудыг ашиглан бие даалт, тайлан бичилт, судалгаа гүйцэтгэх, цуглууласан мэдээлэл дээрээ анализ хийж илтгэл болгон үр дүнг танилцуулах зэргээр хийвэл орчин үеийн технологийг сурч мэдэх давуу тал болно гэж бодож байна.

Санал бичсэн

С.Бямбагэрэл

Багш С.Бямбагэрэл